



# СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№90 /534/

2023.06.05

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

Цаг үе, үйл явдал

## “УЛААНБААТАР МАРАФОН”-Д ЦЭРГИЙНХЭН ӨНГӨЛЖЭЭ



"Улаанбаатар марафон-2023" тэмцээнд Зэвсэгт хүчний мэргэжлийн тамирчнаас гадна сонирхон хичээллэдэг олон алба хаагчид оролцжээ.

Тухайлбал, Үндэсний шигшээ баг болон "Алдар" спорт хорооны тамирчин, ахлах ахлагч Г.Хишигсайхан, Үндэсний шигшээ баг болон Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн тамирчин, ОУХМ, ахлагч Б.Мөнхзаяа, мөн тус ангийн мотобуудлагын батальоны хангалт үйлчилгээний салааны нярав, ОУХМ, дэд ахлагч Б.Сарангуа, Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн хөгжимчин, спортын мастер, ахлах ахлагч Э.Даваажамц нарын олон алба хаагч хамгийн холын зайг сонгож оролцсон байна. Ингээд тамирчдаас хамгийн их тэсвэр хатуужил сорьсон 42 км-ын зайн гүйлтэд эмэгтэйтэйчүүдээс "Алдар" спорт хорооны тамирчин, ахлах ахлагч Г.Хишигсайхан, эрэгтэйчүүдийн төрөлд Н.Мөнхбаяр нар тэргүүлжээ.

Бусад тамирчид нь ч гэсэн өөр өөрийн дархалсан амжилтуудтай бөгөөд ахлагч Б.Мөнхзаяа нь "Рио-2016", "Токио-2020" олимпын наадам, "Лондон-2017", "Доха-2019" Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд эх орноо төлөөлөн оролцсон, "Улаанбаатар марафон" олон улсын гүйлтийн тэмцээнд сүүлийн 7 удаа зохион байгуулагдахад тавд нь буюу 2015, 2016, 2017, 2018, 2022 онд түрүүлсэн аварга. Мөн түүнчлэн 3000, 5000, 10000 метр, хагас марафон, марафон гүйлтийн зайд Монгол Улсын рекорд амжилтыг эзэмшдэг бөгөөд улсын аваргаар 20 удаа тодорсон тамирчин юм.

Дэд ахлагч Б.Сарангуа эх орныхоо 12 цагийн гүйлтийн рекорд эзэмшигч бөгөөд улсын аваргын 2018 оны хүрэл, 2019, 2023 оны мөнгөн медальт алба хаагч бол ахлах ахлагч Э.Даваажамц нь 2021 онд Ховд аймгаас Дорнод аймаг хүртэлх

2100 гаруй км замыг 46 хоногийн хугацаанд туулсан Монгол Улсын олон өдрийн ганцаарчилсан гүйлтийн рекорд эзэмшигч. Ингэхдээ 660 км зайд нь цэргийн хүний ёсоор АК буу үрч гүйснээрээ мөн анхдагч болж чадсан алба хаагч юм. Тэрээр өнөөдөр 42 км замыг 4 цаг 30 минут туулж барианд орсон бөгөөд зохион байгуулагчид монгол цэргийн тэсвэр хатуужлыг өөрөөрөө үлгэрлэдгийг нь үнэлж дурсгалын медаль гардуулжээ.

Цэргийнхний амжилт үүгээр зогсохгүй 42 км-ын зайд Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлээс 10 цэргийн алба хаагч оролцсоноос мотобуудлагын батальоны ШТМ-ын нярав, дэд ахлагч Т.Ариунболд 10, танкийн батальоны ротын захирагч, ахлах дэслэгч Б.Төвжаргал 11, танкийн батальоны салааны ахлагч ахлах ахлагч Ш.Түвшинбаяр 15 дугаар байрт тус тус шалгарчээ.

ЗХЖШ

### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

| ӨДӨР  | ШӨНӨ |
|-------|------|
| ☀️ 31 | 🌧️ 9 |

ӨМНӨД СУДАН

| ӨДӨР  | ШӨНӨ  |
|-------|-------|
| ☀️ 39 | 🌧️ 29 |

### ВАЛЮТЫН ХАНШ

| ВАЛЮТ  | АВАХ  | ЗАРАХ |
|--------|-------|-------|
| USD 🇺🇸 | 3,444 | 3,462 |
| EUR 🇪🇺 | 3,776 | 3,799 |
| CNY 🇨🇳 | 499   | 502   |
| RUB 🇷🇺 | 43.50 | 44.20 |
| JPY 🇯🇵 | 25    | 26,20 |
| KRW 🇰🇷 | 2.56  | 2.61  |

### ЗУРХАЙ



2023.06.05 /ДАВАА ГАРАГ/  
БИЛГИЙН ТООЛЛЫН 16

**ЗУНЫ ТЭРГҮҮН УЛААГЧИН  
МОГОЙ САР  
ДӨРВӨН НОГООН МЭНГЭТЭЙ  
ХӨХ МОРЬ ӨДӨР**

Үс засуулбал:

Өвчин ирнэ  
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:  
04.55-20.46  
Барилдлага:  
Рашаан  
ШҮТЭН БАРИЛДЛАГА:  
Төрөн түгэхүй

Тухайн өдөр нохой, хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Эм найруулах, угаал үйлдэх, бэр авах, насны авшиг, насны бүтээл хийх зан үйл хийгээд төрөл садан бололцох, худалдаа наймааны үйлнээ сайн болой, хувцас хийх, гэр орон барих, сан нуун дарахад сайн. Зүүн нүд татвал эцэг, эх садны хэрэг бүтэх баруун нүд татвал эд олдох, зүүн чих хангинавал аймшиг болох, баруун чих хангинавал хэрүүл тэмцэл болох, хэрээ дуугарвал зочид ирэх, тагнай загатнавал сэтгэл зовох, бүх бие татвал хэрэг олон болох, хөл татвал үзэсгэлэн болно.

## ТӨРИЙН ТОРГОН ЦЭРГҮҮД ТАНГАРАГ ӨРГӨЛӨӨ



Хурандаа генерал Ж.Ёндонгийн нэрэмжит Цэргийн гавьяаны улаан тугийн болон Байлдааны гавьяаны одонт, Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн 2023 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлагаар ирсэн шинэ дайчид Цэргийн тангараг өргөлөө.

Шинэ дайчдын Цэргийн тангараг өргөх ёслолын ажиллагаанд ЗХЖШ-ын ажиллагааны удирдлагын газрын дарга хурандаа Д.Дугаррагчаа, Нийслэлийн Баян зүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын дарга И.Баттөгс, БЗД-ийн цэргийн штабын дарга дэд хурандаа Л.Гантогтох нарын хүндэт зочид, тус ангийн бие бүрэлдэхүүн, шинэ дайчдын ар гэрийн төлөөлөл, оролцлоо.  
Цэргийн тангараг өргөсөн шинэ дайчдад

хандаж ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга хурандаа Д.Дугаррагчаа баяр хүргэж үг хэлэхдээ төрийн торгон цэргийн ангид алба хаах нь нэр төрийн хэрэг бөгөөд цаашдын албанд нь өндөр амжилтыг хүслээ. Мөн тангараг өргөсөн дайчдын ар гэрийг төлөөлөн байлдагч Г.Билгүүний эмээ Монгол Улсын гавьяат багш Б.Гантогтох, байлдагч нарыг төлөөлж байлдагч Б.Молом нар үг хэллээ.

Тангараг өргөсөн шинэ дайчид цэргийн анхан шатны бэлтгэл сургалтаар сурч, мэдсэн зүйлс болох жагсаалын болон гардан тулааны үзүүлэх тоглолтыг ар гэр, найз нөхдөдөө үзүүлж сонирхууллаа. Цэргийн анхан шатны бэлтгэл

сургалтаар онц дүн үзүүлсэн байлдагч нар ангийн захирагчийн тушаалаар 24 цагийн түр чөлөөгөөр шагнагдсан юм.

Энэхүү баярын өдрөөр Зэвсэгт хүчний 032 дугаар анги хугацаат цэргийн алба хаагчдын ар гэр, найз нөхөд, ах дүү нарт "Нээлттэй хаалганы өдөрлөг"-ийг зохион байгуулж, үе үеийн төрийн торгон цэргийн хувцас, зэвсэглэл, техникийн үзэсгэлэнг дэлгэн үзүүллээ.

Эх орондоо тангараг өргөсөн шинэ дайчдадаа цаашдын албанд нь өндөр амжилт хүсэн өрөөө.

Хошууч  
Э.ГАНБАЯР

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 689,942,145

Эдгэрсэн

Нийт: 6,886,752

Нас барсан

Нийт: 662,386,899

Цахим шууданд

## ДЭД АЖЛЫН ХЭСГИЙН ХУРАЛДААНААР ...



чиглэл өгсөн юм.

Өнөөдөр буюу 6 дугаар сарын 2-ны өдөр Зэвсэгт хүчний Жанжин штабын орлогч дарга хурандаа Т.Галбадрахын ахалж буй уг дэд ажлын хэсгийн хуралдааныг зохион байгуулав.

Энэхүү хуралдааны эхэнд ЗХЖШ-ын Сургалт бэлтгэлийн газрын орлогч дарга хурандаа Д.Жигжидсүрэн "Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын залуу офицеруудын чуулган"-ыг угтан хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн явц, цаашид хийх ажлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл хийсэн юм.

Дараа нь дэд ажлын хэсгийн гишүүд өөрсдийн хариуцсан ажлын чиглэлээр харилцан санал солилцож, нэгдсэн ойлголтод хүрэв.

Төгсгөлд нь ЗХЖШ-ын орлогч дарга, дэд ажлын хэсгийн дарга хурандаа Т.Галбадрах ажлын хэсгийн гишүүдэд тулгамдаж буй асуудлын талаар мэдээлэл хийж, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар үүрэг, чиглэл өгсөн юм.

**Хурандаа  
Б.ОТГОНБАЯР**

Энэ оны 9 дүгээр сард Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн ивээл дор "Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын залуу офицеруудын чуулган"-ыг зохион байгуулна.

Уг чуулганыг зохион байгуулах бэлтгэлийг хангах ажлын хүрээнд Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаалаар уг чуулганыг зохион байгуулах төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх дэд ажлын хэсгийг байгуулж, үүрэг,

## БАЙЛДАГЧ Б.БАТХҮЛЭГИЙН СҮЙ ТАВИХ ЁСЛОЛЫГ АНГИ ХАМТ ОЛНООРОО ЗОХИОН БАЙГУУЛЛАА



ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 256 ДУГААР АНГИ

Цэргийн гавьяаны Улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 256 дугаар ангийнхан Зэвсэгт хүчний үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх хүрээнд

"Нээлттэй хаалганы өдөрлөг"-ийг зохион байгууллаа.

Энэхүү өдөрлөгт Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудад төдийлөн явагдаж байгаагүй нэгэн арга хэмжээ багтсан нь хугацаат

цэргийн алба хаагчийнхаа хань ижил, гэр бүлд чиглэсэн сүй тавих ёслол байв.

Баянхонгор аймгийн харьяат байлдагч Батсайханы Батхүлэг, түүний гэргий Сэлэнгэ аймгийн Ерөө сумын харьяат Хүчитбаатарын Болортунгалаг нарын сүй тавих ёслолыг анги хамт олноороо зохион байгуулж, дайчин болон бэрийнхээ аав ээж, ахан дүүсийг урьж нэгэн өдрийг баяр баясал, бахархал дүүрэн өнгөрүүлжээ.

Тус ангийн захирагч хурандаа Н.Гүрбадам "Зэвсэгт хүчний 256 дугаар ангийнхан бид нэгэн гэр бүл билээ. Амжилтаа хамт хүртэж, алдаагаа ч цугтаа үүрдэг хамт олон. Нэгнийхээ баяр жаргал, зовлон гуниг бүрт ч ойрхон байх сан гэж хичээж явдаг нь өнөөдөр байлдагчийнхаа гэргийг хөөрхөн хүү Б.Тэнүүгэн болон өвөө, эмээгийнх нь хамт урьж, амьдралынх нь мартагдашгүй дурсамжийг нь хамтдаа бүтээлцэж байна. Ерөөл учрал бүрдсэн энэ сайхан өдөр хоёр хүүхэд минь хаан бугуйвчаар жаргал нэгтгэж, хатан сүйхээр заяа зангидлаа. Эрхэм байлдагч болон эх орны хөвгүүнтэй заяа холбосон үзэсгэлэнт бэрдээ баяр хүргэе" гэсэн юм.

## НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



БНМАУ-ын баатар хурандаа генерал Ж.Лхагвасүрэнгийн нэрэмжит Цэргийн гавьяаны одонт Зэвсэгт хүчний 167 дугаар анги Монгол Улс энхийг дэмжих ажиллагаанд цэргийн баг илгээсний 20 жилийн ой, "Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-ийн тохиолдуулан нээлттэй хаалганы өдрийг зохион байгууллаа.

Өдөрлөгөөр офицер, ахлагч, ажилтан албан хаагч, түрүүч байлдагч

нарынхаа гэр бүл, үр хүүхдүүдэд хүндэтгэл үзүүлж гарын бэлэг гардуулж, олон арга хэмжээг зохион байгуулав.

Эх орныхоо ирээдүй болсон 3-7 насны багачуудын дунд явуулсан "Нарны хаан хүүхэд" сэдэвт гар зургийн уралдаанд Г.Чингүүн, нэг хүртэлх насныхны "Мөлхөө жаал"-д Г.Мөнххүслэн, М.Хүслэн, Э.Баярцогт, "Би дуулж чадна", тэмцээнд А.Хангал, Ү.Бүрэнтөгс, Г.Мөнхсүвд,

"Бяцхан бүжигчин"-ээр Г.Чингүүн, Ү.Бүрэнтөгс нар тус тус шалгарч, аав ээжийгээ баярлууллаа.

Мөн энэ үеэр ангийн эмэгтэйчүүдийн зөвлөлөөс "Алдарт эх"-ийн одонтой 8 алба хаагчид хүндэтгэл үзүүлж, Мотобуудлагын батальоныхон хугацаат цэргийн албаа үлгэр жишээгээр хааж буй байлдагч Ж.Отгонбаатар, Ж.Отгонбаяр нарын ээж Ж.Өлзийбат, байлдагч Т.Цолмонбаярын ээж Б.Түмэнжаргал, байлдагч Б.Батболдын ээж, байлдагч А.Билгүүний ээж Ц.Отгонцэцэг нарыг өдөрлөгт урин оролцуулж, гарын бэлэг, талархлын захидлын хамт гардуулсан юм.

Цугласан бяцхан үрс болон ээжүүдэд урлагын хэсэгчилсэн концерт, хугацаат цэргийн алба хаагчдын гардан тулаан, жагсаалын үзүүлэх тоглолтыг толилуулж, Өмнөговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас "Хүүхдийн хүмүүжилд эцэг эхийн оролцоо" сэдвээр мэдээлэл хүргэлээ.

## "МОНГОЛ УЛСАД ХИЙСЭН АЙЛЧЛАЛ ҮР ДҮНТЭЙ БОЛЖ ЧАДЛАА"



БНЭУ-ын Үндэсний батлан хамгаалахын коллежийн Стратегийн дамжаанд суралцаж буй Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улс, Оманы Султант Улс, Мьянмар, Бразил, Израил Улс генерал, ахлах офицерууд 5 дугаар сарын 28-наас 6 дугаар сарын 3-ны өдрийг хүртэлх хугацаанд манай улсад айлчилж байгаа билээ. Айлчлалын хүрээнд БХЯ, ЗХЖШ, ҮБХИС-ийн удирдлагуудтай уулзаж, хамтын ажиллагааны өнөөгийн түвшин, сургалтын тогтолцоо зэрэг олон асуудлаар санал солилцсон бол 6 дугаар сарын 2-ны энэ өдөр төлөөлөгчид Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалд ажиллаж байна.

Хуурай замын цэргийн командлагч бригадын генерал Ч.Цогтжаргал айлчлалын хүрээнд олон орны Зэвсэгт хүчний төлөөлөгчид багтаж, Монгол Улсын Зэвсэгт хүчинтэй харилцаа, хамтын ажиллагаагаа улам хөгжүүлэх, бэхжүүлэх тухай ярилцаж байгаад талархал илэрхийлээд бүс нутгийн аюулгүй байдлын талаар санал солилцож, Монгол Улсын Зэвсэгт хүчний түүхэн болон өнөөгийн хөгжлийн чиг хандлагын талаар мэдээлэл хүргэж, командлалын байрыг танилцуулсан юм.

Айлчлалын багийн төлөөлөгчдийн нэг хошууч генерал Ражеш Арун Могхе "Монгол Улс тэр дундаа Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний удирдлагуудын ажил хэрэгч бөгөөд найрсаг зан чанар их таалагдлаа. Олон чиглэлээр цэргийн харилцаа, хамтын ажиллагаагаа тодотгосон үр дүнтэй айлчлал байлаа" гээд Монгол Улсын Зэвсэгт хүчний хөгжлийн түвшин дээшилж, энхийг сахиулах үйлсээрээ бүс нутагтаа төдийгүй НҮБ-д цэрэг хандивлагч шилдэг 24 орны нэг болж яваад нь баяр хүргэж байсан юм.

Ташрамд дурдахад, БНЭУ-ын Үндэсний батлан хамгаалахын коллежийн Аюулгүй байдал, стратегийн дамжаа нь цэргийн болон иргэний өндөр албан тушаалтныг бэлтгэдэг, олон улсад нэр хүндтэй сургалтуудын нэг юм. Тус дамжаанд суралцагч нь олон улсын болон бүс нутгийн аюулгүй байдал, олон улсын хууль, эрх зүй, улс төр, эдийн засаг, олон улсын байгууллага, стратегийн харилцаа, стратеги судлал, аюулгүй байдлын сорилт зэргийг нэг жилийн хугацаанд судлах бөгөөд сургалтын хөтөлбөрийн дагуу бүс нутгийн орнуудаар аялаж, тэдгээрийн улс төр, эдийн засаг, нийгмийн хөгжил, соёлтой танилцах боломжтойгоороо онцлог юм.

## МОНГОЛЫН ЦЭНХЭР ДУУЛГАТНУУД ГАР ХИЙЦИЙН ТОГЛООМ ХИЙЖ БЭЛЭГЛЭВ



НҮБ-ын веб сайтад БНӨСУ-д үүрэг гүйцэтгэж байгаа Монгол Улсын Зэвсэгт хүчний XII ээлжийн цэргийг багийг дахин онцолжээ.

Мэдээлэлд "Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг угтаж Монгол Улсын энхийг сахиулагчид Бентьё хотын дунд сургуулийн сурагчдад чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, нөхөрлөх, бие бялдраа чийрэгжүүлэхэд туслах гар хийцийн тоглоом, дасгалын

тоноглолуудыг хийж, сургуулийн орчинд суурилууллаа. Түүнээс гадна Суданы бяцхан багачуудад бичиг хэрэг, ном, өөрсдийн гараар урласан хувцас хандивлаж олон орны энхийг сахиулагчдад үлгэр жишээ үзүүлээ. Сургуулийн хамт олон чин сэтгэлээсээ талархаж буйгаа үүгээр дамжуулсныг илэрхийлье. Энх тайван гэдэг ийм л чин сэтгэлийн энгийн харилцаанаас эхэлнэ" гэжээ.

**Ахмад Д.БОЛОР**

Дарга дэд хурандаа  
**САЙНБОЛДЫН  
УУГАНБАЯР**

**ЦАХИМ ХАЯГ**  
Батлан хамгаалах яам  
Зэвсэгт хүчний  
Жанжин штаб

**ЦАХИМ ХУУДАС**  
"Соёмбо" редакц  
"Дуулга" студи

\* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.  
\* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.  
\* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон  
Индекс: 10018  
Цахим шуудан:  
Soyombo@mod.gov.mn  
Утас: 70001029, 3412 (дотуур)